

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ 2024 ОНЫ 1-Р УЛИРАЛ

/Аудитлагдаагүй, Монголбанк тайлан суурьтай/

2024 оны 4-р сар



САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ /2024 оны 1-р улирал/

2024 оны 3-р сарын эцсийн байдлаар улсын инфляц оны эцэстэй харьцуулахад 7.9%-аас 7.0%-д хүрч буурав. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо энэ оны 3-р сард хуралдаж бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 12%-д хүргэх шийдвэр гаргалаа. Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэстэй харьцуулахад тогтвортой байж 2024 оны 2-р сарын эцсийн байдлаар 37.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 24.3%-р өссөн байна. Харин Гадаад валютын нөөц 3-р сарын эцсийн байдлаар 5.2 тэрбум ам долларт буюу түүхэн дээд хэмжээнд хүрч өссөнөөр төгрөгийн ханш ам.долларын эсрэг чангарч, улмаар ам долларын ханш 3,375.99 төгрөгт хүрээд байна.


2024 оны 1-р улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс харилцагчийн эх үүсвэр 29.0%-р, нийт зээл 37.4%-р тус тус өсөв. Банкны салбарын зах зээлд эзлэх хувь 2 сарын байдлаар харилцагчийн эх үүсвэрийн хэмжээгээр 20.3%, зээлийн хэмжээгээр 18.0%-д хүрч өсөв.

Банк зээлийн багцаа тэлж мөн зах зээл дээр хүүгийн түвшин өндөр байсантай холбоотой 2024 оны 1-р улирлын эцсээр хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 30.5%-р өсөж 279.8 тэрбум төгрөгт, цэвэр хүүгийн орлого 21.8%-р өсөж 126.8 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн бизнесийн өсөлт, зах зээл зээлийн орчны нөлөөгөөр банкны цэвэр хүүгийн бус орлого 105.6%-р өсөв. Зардлын хяналтыг хэрэгжүүлснээр зардал орлогын харьцааг 33.0%-д хадгалж чадлаа.

Сан үнэлгээний зардлын өмнөх, свопын нөлөөгүй үйл ажиллагааны цэвэр ашиг 25.5%-р өсөж 111.6 тэрбум төгрөгт хүрэв. Активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн харьцаа (NPL) өмнөх оны мөн үе 8.5%-аас 4.3% хүрч буурсан бол сан үнэлгээний зардал 81.7%-р буурч 7.6 тэрбум төгрөгт хүрэв.

2023 оны татварын дараах цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 156.1%-р өсөж 86.2 тэрбум төгрөгт хүрээд байна. Мөн цэвэр хүүгийн ахиуц харьцаа (NIM) өмнөх оны мөн үеийн 6.1%-с 6.3%-д хүрч, Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 15.6%-с 35.0%-д хүрч сайжрав.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ /2024 оны 2-р сар/



Арилжааны хэмжээ
26%



Онлайн худалдааны
гүйлгээний тоо, дүн
69%, 45%

Q3'2023 байдлаар



Кастодиан банкны
харилцагчийн тоо
44%



Орон сууцны зээл
24%



Кредит карт
48%



Аккредитивын хэмжээ
75%

Эх сурвалж: Монголбанкны статистик ашиглав

БАЛАНСЫН ГҮЙЦЭТГЭЛ Q1'2024


Балансын үзүүлэлт (тэрбум ₮)	2023Q1	2023Q4	2024Q1	YTD	%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,188	3,614	2,233	(1,380.3)	-38.2%
Банк санхүүгын байгууллагад байршуулсан хөрөнгө	1,471	1,203	901	(301.9)	-25.1%
Хөрөнгө оруулалт	831	1,175	1,266	91.1	7.8%
Цэвэр зээл	3,651	4,576	5,141	565.1	12.3%
Үндсэн хөрөнгө	385	559	565	6.5	1.2%
Бусад актив	554	343	238	(105.0)	-30.6%
Нийт хөрөнгө	9,080	11,469	10,344	(1,124.5)	-9.8%
Харилцагчдын эх үүсвэр	5,788	7,725	7,467	(257.7)	-3.3%
Харилцах	2,727	3,979	3,819	(160.3)	-4.0%
Хадгаламж	3,060	3,745	3,648	(97.4)	-2.6%
Банк санхүүгын байгууллагаас татсан эх үүсвэр	2,004	2,193	1,382	(810.5)	-37.0%
Бусад эх үүсвэр	312	380	256	(123.2)	-32.5%
Бусад өр төлбөр	99	225	216	(8.4)	-3.8%
Нийт өр төлбөр	8,203	10,522	9,322	(1,199.8)	-11.4%
Нийт өөрийн хөрөнгө	877	947	1,022	75.3	8.0%
Чанаргүй зээлийн харьцаа	8.5%	5.0%	4.3%		
Эрсдэлийн хүрэлцээний харьцаа	83.3%	106.2%	111.7%		
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR, Tier 1)	17.5%	15.9%	15.3%		
ТТГЧ-ын харьцаа	36.7%	38.3%	36.8%		

Аудитлагдаагүй, Монголбанк тайлан суурьтай

Балансын гүйцэтгэл:

- Харилцагчдын эх үүсвэр өнгөрсөн оны эцсээс 257.7 тэрбум төгрөгөөр /3.3%/ буурч 7.5 их наяд төгрөгт хүрэв. Корпорэйт сегментийн эх үүсвэр улирлын нөлөөгөөр буурсан байна.
- Цэвэр зээл 565.1 тэрбум төгрөгөөр /12.3%/ өсөж 5.1 их наяд төгрөгт хүрэв. Нийт өсөлтийн 59%-г Ритэйл зээлийн өсөлт бүрдүүлж байна.
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR) болон 1-р зэргийн өөрийн хөрөнгийн (Tier1) хүрэлцээний харьцаа 15.3%-д хүрэв.

Сегментийн бүтэц (%)*



* Дотоод сегментийн бодлогын дагуу




ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ Q1'2024

Орлогын тайлан (тэрбум ₮)	2023Q1	2023Q4	2024Q1	YoY	%
Хүүгийн орлого	214.4	962.0	279.8	65.4	30.5%
Хүүгийн зардал	110.2	507.3	153.0	42.7	38.8%
Цэвэр хүүгийн орлого	104.2	454.7	126.8	22.7	21.8%
Цэвэр хүүгийн бус орлого	22.8	(3.1)	46.9	24.1	105.6%
Шимтгэл хураамжийн орлого	22.8	103.3	26.2	3.3	14.5%
Цэвэр арилжааны ашиг	11.0	(56.4)	28.5	17.6	160.4%
Арилжааны ашиг	16.0	59.0	21.2	5.2	32.7%
СВОП-ын нөлөө	(5.0)	(115.4)	7.3	12.3	244.4%
Бусад хүүгийн бус орлого	2.7	13.0	7.3	4.5	167.7%
Хүүгийн бус зардал	13.7	63.0	15.0	1.3	9.8%
Үйл ажиллагааны орлого	127.0	451.6	173.7	46.7	36.8%
Үйл ажиллагааны орлого /СВОП-гүй/	132.0	567.0	166.4	34.4	26.1%
Үйл ажиллагааны зардал	43.1	198.3	54.8	11.7	27.2%
Үйл ажиллагааны ашиг	83.8	253.4	118.9	35.0	41.8%
Үйл ажиллагааны ашиг /СВОП-гүй/	88.9	368.8	111.6	22.7	25.5%
Эрсдэлийн сангийн зардал	41.4	22.4	7.6	(33.9)	-81.7%
Татварын өмнөх ашиг	42.4	231.0	111.3	68.9	162.5%
Татварын зардал	8.7	50.2	25.1	16.3	187.2%
Цэвэр ашиг	33.7	180.8	86.2	52.5	156.1%
Цэвэр хүүгийн ахиуц*	6.1%	6.3%	6.3%		
Зардал орлогын харьцаа /СВОП-гүй/	32.7%	35.0%	33.0%		
Өөрийн хөрөнгийн өгөөж	15.6%	20.5%	35.0%		
Нийт хөрөнгийн өгөөж	1.6%	1.9%	3.2%		

* Дотоод аргачлал

Аудитлагдаагүй, Монголбанк тайлан суурьтай

Улирлын цэвэр ашиг /тэрбум ₮/



Улирлын цэвэр ашгийн өсөлт(QOQ):

Q1'2024/Q1'2023 +156.1%

Ашигт ажиллагааны гүйцэтгэл:

- Цэвэр хүүгийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 21.8% өсөж 126.8 тэрбум төгрөгт хүрэв.
- Цэвэр хүүгийн бус орлогын хувьд 105.6% өсөж 46.9 тэрбум төгрөгийн орлоготой гарсан.
- Сангийн зардлын өмнөх своп нөлөөгүй цэвэр үйл ажиллагааны ашиг 25.5%-р өсөж 111.6 тэрбум төгрөгт хүрсэн үр дүнтэй байна.
- Сангийн зардал 81.7%-р буурч 7.6 тэрбум төгрөгт хүрэв.
- Татварын дараах цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс 156.1%-р өсөж 86.2 төгрөгт хүрэв.
- Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүдээр өнгөрсөн оноос сайжирсан үр дүнтэй байна.

АНХААРУУЛГА

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг мөрддөг бол Арилжааны банк нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг дагаж мөрддөг. Энэхүү журамд 2017 оноос хойш шинэчлэгдсэн зарим стандарт (СТОУС-9, СТОУС-15, СТОУС-16 гэх мэт)-ын өөрчлөлтийг тусгаагүй байдаг. Иймд дээрх журмын дагуу бэлтгэн улирал бүр олон нийтэд мэдээлж буй тайлан нь Банкны СТОУС-т нийцсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй байж болох ба зээл, эх үүсвэрийн сегментийн бүтцийг банкны дотоод аргачлалд тулгуурласан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа